

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

(Хорих б/гын АХ-дын ажлын онцгойн нэмэгдэл)

2011 оны 6 дугаар сарын 22-ны өдөр Дугаар 189 Улаанбаатар хот

Төрийн албаны тухай хуулийн 28.2.3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 137.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хорих байгууллагын албан хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох хорих байгууллагын албан хаагчдын жагсаалтыг баталж, 2012 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгасугай.

3. Хорих байгууллагын албан хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход шаардагдах зардлыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Сангийн сайд С.Баярцогт нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд С.БАТБОЛД

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.НЯМДОРЖ

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДАД
АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН
НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Хорих байгууллагын албан хаагчдад төрийн тусгай алба хааж байх хугацаанд нь албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг хорих байгууллагын албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож сар бүр олгоно:

№	Албан ажлын онцгой нөхцөлийн олгох алба нэмэгдэл	Нэмэгдлийн хэмжээ (үндсэн цалингийн хувиар)
1	Гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих 461 дүгээр анги, эмэгтэйчүүдийн хорих 407 дугаар анги	20
2	Баривчлах байр, жирийн дэглэмтэй хорих анги, Согтуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар, насанд хүрээгүйчүүдийн хорих 411 дүгээр анги, аймгууд дахь цагдан хорих байр	15
3	Бусад алба	10

3. Хорих байгууллагын албан хаагчдад олгох албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг тухайн байгууллагын төсвөөс олгоно.

4. Хорих байгууллагын албан хаагчдийн албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай, жирэмсний болон амаржсаны амралттай байх хугацаанд олгохгүй.

-----oOo-----